



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

АЖЛЫН ТАЙЛАН
(2016-2020)



SKY

БАРДИН БАЙД МЭНЭГЛЭЛ
ИЛЭГЭЭ ЭХЭЛЭЭЭ
6329. 7700-9919



Мэндчилгээ

Нийслэл хотынхоо хойморт Чингэлтэй хайрхнаараа овоглосон Чингэлтэй дүүргийн иргэд Та бүхнийхээ амар мэндийг эрэн мэндчилье.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2016-2020 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах, Хурлын байгууллагын ил тод, нээлттэй, шуурхай байдлыг хангаж, иргэдээ дээдэлсэн, өрхийн хөгжлийг дэмжсэн, бие даасан эдийн засагтай, бизнест ээлтэй, ногоон хөгжил бүхий дүүрэг болох зорилтыг дэвшүүлэн бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нутгийн захиргааны байгууллагаас Төр засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, эрүүл мэнд, боловсрол, урлаг соёлын үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох, Төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийнхээ эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр салбар бүрт үр дүн бүхий бүтээлч ажлуудыг дүүргийнхээ онцлогт нийцүүлэн иргэдийнхээ оролцоотойгоор хийж хэрэгжүүллээ.

Өнгөрсөн хугацаанд иргэдийнхээ оролцоонд түшиглэсэн олон олон шинэлэг, сайн туршлага болохуйц ажлуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг иргэдийнхээ сайн сайхны төлөө ажил хэрэг болгон боловсрол, эрүүл мэндийн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн, тохижилт бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлсэн, хөгжилд тэмүүлсэн их бүтээн байгуулалтын он жилүүд байлаа.

Бидний хийж бүтээсэн бүхэн иргэдийн сэтгэлд нийцсэн, тэдний эрүүл аюулгүй, тав тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, талархлыг нь хүлээсэн ажлууд болсон гэдэгт итгэлтэй байна.

Цаашид Чингэлтэйчүүд бидэнд батлагдсан төсөв, хөрөнгө оруулалтаа бодит ажил болгохын тулд цаг наргүй хөдөлмөрлөж, дүүрэг орон нутгаа хөгжүүлэхээр төлөвлөсөн олон ажлууд байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Бүрэн эрхийн хугацаанд дэвшүүлсэн бодлого, зорилтоо хэрэгжүүлэхэд идэвх, санаачлага гарган ажилласан Хурлын Төлөөлөгчид, нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчид, дэмжиж хамтран ажилласан дүүргийнхээ нийт иргэд Та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ийнхүү хоймор дүүргийн эзэд Чингэлтэйчүүд Та бүхэндээ дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаанд (2016-2020) хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа дэлгэн толилуулж байна.

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
ЛХААСҮРЭНГИЙН АРИУНТУЯА

АГУУЛГА



1. ХУРЛЫН ХУРАЛДААН

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Чингэлтэй хайрхан уулын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн тусгай хамгаалалтад авах шийдвэрийг батлав.



5. ЭРҮҮЛ МЭНД-2020

Жишиг Өрхийн эмнэлгүүд байгуулагдаж, эрүүл мэндийн чанар, хүртээмж нэмэгдсээр байна.



2. ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Хурлын Тэргүүлэгчид 71 удаа хуралдаж, 241 тогтоол шийдвэрийг батлав.



3. ХУРЛЫН ХОРООД

Хурлын хороод хууль тогтоомж, хурлын шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавин ажиллалаа.



4. ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХЯНАЛТТАЙ ОРЧИН

Иргэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд сайн дураараа оролцож, эрүүл аюулгүй, хяналттай орчинг бүрдүүлж байна.



7. ХОТЫН ИРГЭН ХОТЫН СОЁЛ

Иргэдийг соён гэгээрүүлэх, амьдралын нийтлэг соёлыг төлөвшүүлэх, үндэсний өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх "Хотын иргэн- Хотын соёл" хөтөлбөр амжилттай хэрэгжлээ.



6. ЧИНГЭЛТЭЙН БОЛОВСРОЛ-2020

Дүүргийн хэмжээнд 29 цэцэрлэг шинээр байгуулагдаж, сургуулийн өмнөх боловсролын хүртээмж нэмэгдлээ.



10. ЧИНГЭЛТЭЙД ҮЙЛДВЭРЛЭВ

Чингэлтэйд үйлдвэрлэв
1, 2, 3 төвүүдийг
байгуулж, өрхийн
үйлдвэрлэл эрхлэгчдийг
дэмжин ажиллаж байна.



9. ХАМТДАА ХӨГЖЬЕ

Чингэлтэй дүүрэг
залуучуудын гарааны
бизнесийг эхлүүлэх
төслийг дэмжин, ажлын
байрыг нэмэгдүүллээ.



12. НОГООН ДҮҮРЭГ

Дүүргийн нутаг
дэвсгэрт сул шороон
хөрс бүхий 201,627 м2
талбайг зүлэгжүүлж,
ногоон байгууламжийг
нэмэгдүүлэв.



11. ГАМШГААС ХАМГААЛАХ

Дүүргийн нутаг дэвсгэрт
Гамшгаас хамгаалах
сайн дурын хэсэг, багууд
байгуулагдлаа.



8. ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ

Чингэлтэй дүүрэгт “Гэрч
хохирогчийг хамгаалах
нэг цэгийн үйлчилгээний
төв” байгуулагдлаа.



13. ГАДААД ХАРИЛЦАА

Хамтын ажиллагаа
бүхий Улс орнуудтай
боловсрол, эрүүл
мэнд, хот тохижилт,
ногоон байгууламжийг
нэмэгдүүлэх чиглэлээр
санамж бичиг байгуулан
хамтран ажиллаж байна.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ 2016-2020



Тэргүүлэгч
С.АМАРБАЯСГАЛАН



Хурлын дарга
Л.АРИУНТУЯА



Тэргүүлэгч
Б.БАТХУЯГ



Тэргүүлэгч
Д.ОТГОНБААТАР



Тэргүүлэгч
Х.АЛТАНШАГАЙ



Тэргүүлэгч
Б.ЦОГЗОЛМАА



Тэргүүлэгч
Б.НАСАНБАТ



Төлөөлөгч
Н.САЙНБОЛД



Төлөөлөгч
С.МӨНГӨНСАР



Төлөөлөгч
Ж.ЧИМЭДЦОГЗОЛ



Төлөөлөгч
С.ОТГОНСУРЭН



Төлөөлөгч
Ч.БОЛОРМАА



Төлөөлөгч
Ц.ДУЛАМЖАВ



Төлөөлөгч
Д.БАЯНБАТ



Төлөөлөгч
Д.МӨНХЧУЛУУН



Төлөөлөгч
Л.БАЯРСАЙХАН



Төлөөлөгч
Н.ОЮУНЦЭЦЭГ



Төлөөлөгч
Ц.БУГАСҮРЭН



Төлөөлөгч
Ж.ЛХАГВАСҮРЭН



Төлөөлөгч
Д.НЭМЭХБАТ



Төлөөлөгч
О.ЕСӨНТӨМӨР



Төлөөлөгч
Ш.БАТСҮРЭН



Төлөөлөгч
Г.БАДАМГАРАВ



Төлөөлөгч
З.БЯМБАЖАВ



Төлөөлөгч
Д.БАТ-ЭРДЭНЭ



Төлөөлөгч
С.ЭНХТАЙВАН



Төлөөлөгч
Д.ЯДАМЖАВ



Төлөөлөгч
Б.МӨНХБАТ



Төлөөлөгч
Т.ИДЭРЦАГААН



Төлөөлөгч
Д.МӨНХТӨР



Төлөөлөгч
В.ХҮРЭЛБААТАР



Төлөөлөгч
Д.МӨНХБАТ



Төлөөлөгч
Н.ОЮУНГЭРЭЛ



Төлөөлөгч
Ж.АЛТАНТУУЛ



Төлөөлөгч
О.ЦЭНДДОРЖ

■ ХУРЛЫН ХУРАЛДААН



ХУРАЛДААНЫ ТОО

9

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

34

БАТАЛСАН ШИЙДВЭР

34

ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

- 2017 оныг “Эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлав.
- 2018 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлав.
- 2019 оныг “Иргэдийнхээ хөгжлийг дэмжих жил” болгон зарлав.
- 2020 оныг “Нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих жил” болгон зарлав
- Чингэлтэй дүүргийн Газрын зэрэглэл /бүс/-ийн газрын төлбөр тооцох итгэлцүүрийн тоон утга, түүнийг хэрэглэх газрын зааг, хязгаарыг тогтоов.
- Чингэлтэй хайрхан уулын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн тусгай хамгаалалтад авав.

■ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН



ХУРАЛДААНЫ ТОО	71
ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ	307
БАТАЛСАН ШИЙДВЭР	241

ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:

- Ерөнхий боловсролын сургууль бүрт “Өсвөрийн сэргийлэгч” сайн дурын бүлгэмийг байгуулав.
- Дүүргийн нутаг дэвсгэрт зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэх байршил, үйл ажиллагааны чиглэлийг тогтоов.
- Хороо бүрт Улс, Нийслэл дүүрэг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний явц, гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулав.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ:

- Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичиг
- Ногоон дүүрэг хөтөлбөр
- Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр
- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр
- Эрүүл мэнд -2020 хөтөлбөр
- Чингэлтэйн боловсрол-2020 хөтөлбөр
- Жаргалтай гэр бүл хөтөлбөр
- Хотын иргэн- Хотын соёл хөтөлбөр
- Хамтдаа хөгжье хөтөлбөр
- Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөр
- Иргэдийн оролцоотой хяналттай орчин хөтөлбөр



Дарга: Д.Ядамжав
 Гишүүд: Д.Мөнхтөр, Д.Баянбат,
 З.Бямбажав, Л.Ариунтуяа, Ц.Бугасүрэн,
 Д.Мөнхчулуун



Дарга: Н.Оюунцэцэг
 Гишүүд: Д.Мөнхбат, Л.Баярсайхан,
 Б.Батхуяг, Д.Бат-Эрдэнэ, Н.Сайнболд,
 Ц.Бугасүрэн



Дарга: С.Мөнгөнсар
 Гишүүд: Ж.Лхагвасүрэн, Б.Батхуяг,
 С.Энхтайван, С.Отгонсүрэн,
 Ш.Батсүрэн, О.Есөнтөмөр



Дарга: Б.Цогзолмаа
 Гишүүд: Г.Бадамгарав,
 В.Хүрэлбаатар, О.Цэнддорж,
 Н.Оюунгэрэл, Д.Ядамжав, Д.Баянбат

■ ХУРЛЫН ХОРООД

ЭРХ ЗҮЙ, НУТГИЙН УДИРДЛАГЫН ХОРОО:

Чиг үүрэг: Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн хэрэгжилт, гэмт хэрэг, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бодлого үйл ажиллагаа, гадаад, дотоод харилцаа, Төрийн захиргааны байгууллагын удирдлага, зохион байгуулалтад хяналт тавих;

Хуралдааны тоо **18**

Хяналт шалгалт **7**

Санал дүгнэлт **13**

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ХОРОО:

Чиг үүрэг: Дүүргийн төсөв, санхүү, хөрөнгө, оруулалт, татварын бодлого, үйл ажиллагаа, орон нутгийн өмчийн харилцаанд хяналт тавих;

Хуралдааны тоо **10**

Хяналт шалгалт **2**

Санал дүгнэлт **9**

ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ХЯНАЛТЫН ХОРОО:

Чиг үүрэг: Дүүргийн төсвийн зарцуулалт, түүний гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт тавих;

Хуралдааны тоо **10**

Хяналт шалгалт **6**

Санал дүгнэлт **14**

НОГООН ХӨГЖИЛ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХОРОО:

Чиг үүрэг: Байгаль орчин, ногоон байгууламж, экологийн асуудал, хог хаягдлын менежмент, газар зохион байгуулалт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

Хуралдааны тоо **10**

Хяналт шалгалт **4**

Санал дүгнэлт **7**

ХОТ БАЙГУУЛАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖЛИЙН ХОРОО:

Чиг үүрэг: Барилга, хот байгуулалт, дэд бүтэц, зам талбайн тохижилт, орон сууц, нийтийн аж ахуй, гэр хорооллын хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөр, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтад хяналт тавих;

Хуралдааны тоо **30**

Хяналт шалгалт **13**

Санал дүгнэлт **15**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХОРОО:

Чиг үүрэг: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хүн ам зүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хяналт тавих;

Хуралдааны тоо **31**

Хяналт шалгалт **12**

Санал дүгнэлт **22**

ЁС ЗҮЙ, ӨРГӨДЛИЙН ХОРОО:

Чиг үүрэг: Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, бүх нийтийн санал асуулга, олон нийтийн санаа бодлын тандалт судалгаа, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;

Хуралдааны тоо **11**

Хяналт шалгалт **3**

Санал дүгнэлт **7**



Дарга: Б.Насанбат
Гишүүд: Ц.Дуламжав, Б.Мөнхбат,
Д.Отгонбаатар, Ч.Болормаа,
Т.Идэрцагаан, Ш.Батсүрэн



Дарга: Г.Бадамгарав
Гишүүд: Д.Нэмэхбат, Ж.Чимэдцогзол,
С.Мөнгөнсар, О.Есөнтөмөр, Б.Насанбат,
Ж.Алтантуул



Дарга: Л.Ариунтуяа
Гишүүд: Х.Алтаншагай, Д.Мөнхтөр,
С.Амарбаясгалан, З.Бямбажав,
Д.Нэмэхбат, Д.Мөнхчулуун

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХЯНАЛТТАЙ ОРЧИН



ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 34 ДҮГЭЭР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Нийгмийн дэг журмыг хангах, дүүргийн хүн амыг эрүүл аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог бий болгох, татан оролцуулах, үүрэгжүүлж, хариуцлагажуулах, урамшуулах, хамтран ажиллах замаар гэмт хэрэг зөрчилгүй, хяналттай, амар тайван орчныг бүрдүүлж, хэрэг зөрчилгүй дүүрэг болох;

Зорилтын тоо:

8

Биелэлтийн хувь:

90

Арга хэмжээний тоо:

30



- “Миний гудамж - Гэмт хэрэг зөрчилгүй гудамж” 3 сарын аяныг хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулав.
- “Гэмт хэрэг зөрчилгүй байгууллага, хамт олон” 8 сарын аян дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй томоохон Худалдаа үйлчилгээний төвүүд, захуудын дунд зохион байгуулав.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бичил төслийн уралдааныг хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багуудын дунд зохион байгуулав.



“Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэвшилтэд техник технологийг ашиглах нь” сэдэвт Анхдугаар зөвлөгөөнийг дүүргийн хэмжээнд зохион байгуулав.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан авто замын хэвтээ, босоо тэмдгийг дүүргийн нутаг дэвсгэрт төв зам дагуу байршуулав.



Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт 270 ширхэг хяналтын камерийг шинээр суурилуулж, камерийн сүлжээг Чингэлтэй дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэстэй холбов.



Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль бүрт “Өсвөрийн сэргийлэгч сайн дурын бүлгэм”-ийг байгуулав.



Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох “Ногоон гэрэл - Цагаан шугам” тэмцээнийг жил бүр амжилттай зохион байгуулав.



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах ажилд дүүргийн 800 гаруй иргэд сайн дураараа оролцож, гудамж, байр бүрт нийтийн эргүүлээр ажиллаж байна.




Дүүрэг дэх Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэст Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд, гэрч хохирогч, хүүхдийг түр хамгаалах өрөөг байгуулж, иж бүрэн тохижуулав.



Дүүрэг дэх Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын цагдаагийн хэлтэст тус бүр Лада маркийн авто машиныг олгов.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТОО



Дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн хэргийн 57,2 хувь нь 1-9 дүгээр хороонд, 42,8 хувь нь 10-19 дүгээр хороонд үйлдэгдсэн ба 2019 онд 1-9 дүгээр хороонд бүртгэгдсэн гэмт хэрэг 1,8 хувиар, 10-19 дүгээр хороонд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 9,2 хувиар тус тус буурчээ



**“ЭРҮҮЛ МЭНД-2020”
ХӨТӨЛБӨР**

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 24 ДҮГЭЭР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Орчин үеийн стандарт, мэдээлэл технологийн ололтод тулгуурласан анхан болон лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг багасгах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд Төрийн болон Төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоог нэмэгдүүлэх;

Зорилтын тоо: **6**
Арга хэмжээний тоо: **48**

Биелэлтийн хувь: **86,4**



Дүүргийн 13, 14 дүгээр хороонд Өрхийн эрүүл мэндийн төвийг байгуулав.



Дүүргийн 17 дугаар хороонд "ТИКА" Олон Улсын байгууллагатай хамтран жишиг Өрхийн эрүүл мэндийн төвийг байгуулж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 14 дүгээр хороонд Яаралтай түргэн тусламжийн төвийг байгуулж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 16 дугаар хороонд Өрхийн эрүүл мэндийн төвийг байгуулж байна.



Улсын хэмжээнд анх удаа 1050 м2 талбай бүхий жишиг Өрхийн эрүүл мэндийн төв-ийг 12 дугаар хороонд байгуулж, Олон Улсын стандартын шаардлага хангасан дүрс оношилгооны рентген аппарат, цахилгааны нөөц үүсгүүрээр хангав.



Дүүргийн 7-19 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг автомашин, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангав.



Дүүргийн Эрүүл мэндийн төв болон 11, 12, 13, 17, 18, 19 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд мобайл технологийн багцыг олгож, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулав.



Дүүргийн эрүүл мэндийн салбарт E-health нэгдсэн цахим программ хангамж нэвтрүүлж, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлж, 180,667 иргэний эрүүл мэндийн талаарх мэдээллийн нэгдсэн санг үүсгэв.



Эрүүл мэндийн төвийн бага тойруу салбарыг бүрэн засварлаж, мэс заслын тасгийг шинээр байгуулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангав.



Сэтгэлд нийцсэн угтах үйлчилгээ төслийн хүрээнд дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн хүлээлгийн танхимыг засаж тохижуулав.



Дүүргийн ерөнхий боловсролын 24, 37, 39, 72 дугаар сургуулиудын эмчийн өрөөг засаж тохижуулав.



Дүүргийн 1, 2, 3 дугаар хороонд “Жишиг Өрхийн эрүүл мэндийн төв” байгуулах ажлыг эхлүүлэв.



Дүүргийн 4 дүгээр хороонд “Хороо, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг”-ийн цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэв.



Эрүүл мэндийн чиглэлээр зохион байгуулсан сургалт, өдөрлөг, арга хэмжээнд 235880 (давхардсан тоогоор) иргэдийг хамруулав.



“ЧИНГЭЛТЭЙН БОЛОВСРОЛ-2020” ХӨТӨЛБӨР

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 29 ДҮГЭЭР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого чиглэл, нийслэл дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан үр дүнтэй хэрэгжүүлж, удирдлагын зөв менежмент, багшийн арга зүй технологийг дэлхий нийтийн чиг хандлага, боловсролын салбарын зорилго, зорилттой нийцүүлэн авч явах, боловсролын харилцаанд оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх замаар сургалтын чанарыг сайжруулах;

Зорилтын тоо:
Арга хэмжээний тоо:

5
25

Биелэлтийн хувь:

94



Дүүргийн 7 дугаар хороонд 150 ортой 224 дүгээр цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 8 дугаар хороонд 150 ортой 245 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 11 дүгээр хороонд 175 ортой 275 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 16 дугаар хороонд 150 ортой 246 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 18 дугаар хороонд 150 ортой 247 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 17 дугаар хороонд 150 ортой 222 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 1 дүгээр хорооны 33 дугаар цэцэрлэг, 4 дүгээр хорооны 4, 9, 39 дүгээр цэцэрлэгүүд, 9 дүгээр хорооны 43 дугаар цэцэрлэгийн байрыг буулган шинэчилж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 6 дугаар хорооны 74 дүгээр цэцэрлэг, 17 дугаар хорооны 103 дугаар цэцэрлэгийн барилгыг өргөтгөв.



“Сэлбэ дэд төв”-ийн хүрээнд дүүргийн 18 дугаар хороонд 240 хүүхдийн ортой 280 дугаар цэцэрлэгийг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 4 дүгээр хороонд 200 ортой 37 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 16 дугаар хороонд 150 ортой 293 дугаар цэцэрлэгийг шинээр барьж байна.



Дүүргийн 10 дугаар хороонд 200 ортой 292 дугаар цэцэрлэгийг шинээр барьж байна.



Дүүргийн 12 дугаар хороонд 180 суудалтай 138 дугаар бага сургууль, 120 ортой 220 дугаар цэцэрлэгийн цогцолборыг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 16 дугаар хороонд 180 суудалтай 139 дүгээр бага сургууль, 120 ортой 221 дүгээр цэцэрлэгийн цогцолборыг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 17 дугаар хороонд 180 суудалтай 140 дүгээр бага сургууль, 120 ортой 222 дугаар цэцэрлэгийн цогцолборыг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 11 дүгээр хороонд 240 ортой 258 дугаар цэцэрлэгийг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 3 дугаар хорооны 19 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийг барьж, 150 ороор нэмэгдүүлэв.



Дүүргийн 15 дугаар хорооны 102 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 2 дугаар хорооны 70 дугаар цэцэрлэгт 2 нэмэлт бүлгийг байгуулж, 14 дүгээр хорооны 126 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 12 дугаар хорооны 154, 17 дугаар хорооны 174 дүгээр цэцэрлэгийг тус тус шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 102, 74 дүгээр цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэв.



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ



Дүүргийн 5, 23, 24, 50 дугаар сургуулиудын өргөтгөлийг барьж, 1540 хүүхдийн суудлаар нэмэгдүүлэв.



Дүүргийн 7 дугаар хороонд “Жайка” Олон Улсын байгууллагын санхүүжилтээр 700 хүүхдийн суудалтай бага сургуулийг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 72 дугаар сургуулийн урлаг заалыг засварлан тохижуулж, 5, 17, 37, 39, 49, 57, 61 дүгээр сургуулиудын технологийн кабинетыг хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан “Юнимат” төхөөрөмжөөр хангав.



Дүүргийн 23 дугаар сургуульд цахим номын сангийн өргөтгөлийн барилгыг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 24 дүгээр сургуулийн спорт заалыг засч, тохижуулав.



Ерөнхий боловсролын 12 сургуульд 3D принтер бүхий тоног төхөөрөмжийг олгож, хэрэглээнд нэвтрүүлэв.



Дүүргийн Төрийн өмчийн 12 сургуульд “Роботик” төслийг амжилттай хэрэгжүүлэв.



Дүүргийн 23, 49 дүгээр сургуулиудад “Монгол бичиг”-ийн кабинетыг нээн тохижуулав.



Дүүргийн 50 дугаар сургуульд “Угийн бичгийн кабинет”-ийг шинээр нээн тохижуулав.



Дүүргийн 320 суралцагчийн хүчин чадалтай Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг барьж байна.



Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсу дүүрэгтэй хамтран хэрэгжүүлж буй “Сурагч солилцоо”-ны хөтөлбөрт дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын багш, сурагчдыг хамруулав.





**“ХОТЫН ИРГЭН-ХОТЫН
СОЁЛ” ХӨТӨЛБӨР**

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 26 ДУГААР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Үндэсний өв соёл, түүхээ тээн хөгжүүлэгч, нийслэл хотынхоо өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл явцад оролцох өсвөр, залуу үеийнхнийг бэлтгэж, урлаг, спорт, соёлын ажил үйлчилгээгээр дамжуулан Хотын зөв иргэн, зөв соёлыг төлөвшүүлэх;

Зорилтын тоо:
Арга хэмжээний тоо:

5
23

Биелэлтийн хувь:

97,3

СОЁЛЫН ӨДӨРЛӨГ ФЕСТИВАЛЬ



Чингэлтэй хайрхныг тайж тахиx Их тахилгыг иргэдийн оролцоотойгоор зохион байгуулав.



Ёс заншлаа түгээн дэлгэрүүлэх “Амар байна уу? та” дүүргийн соёлын фестивалийг зохион байгуулав.



Өв соёлоо түгээн дэлгэрүүлэх “Монгол бахархал” дүүргийн соёлын фестивалийг зохион байгуулав.



“Гудамжны баяр” дүүргийн соёлын фестивалийг зохион байгуулав.



“Монгол урлагийн гайхамшиг” үндэсний урлагийн тоглолтыг зохион байгуулав.



Соёл урлагийг түгээх дэлгэрүүлэх “Соёлын наадам-2017” дүүргийн фестивалийг зохион байгуулав.



Сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд Оросын Холбооны Улсын Саха /Якут/ Улсын Хангаласский дүүргийн Улан-Үдэ хотод 30 сурагчийг хамруулав.



Сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсу дүүрэгт 60 сурагчийг хамруулав.



Сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд Бүгд найрамдах Турк Истанбул хотын Пендик дүүрэгт 22 сурагчийг хамруулав.



Сурагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд Бүгд найрамдах Япон Улсын Шизүока мужийн Яйзу хотод 18 сурагчийг хамруулав.



Дүүргийн 10 дугаар хороонд Усан бассейн, мөсөн гулгуурын талбай бүхий 1000 хүний суудалтай спорт цогцолборыг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 19 дүгээр хороонд Соёл, спорт, амралт, аялал жуулчлалын цогцолборыг шинээр барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 19 дүгээр хороонд Иргэд, хүүхэд, залуучууд ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заалыг барьж, ашиглалтад оруулав.



Дүүргийн 7 дугаар хороонд Иргэд, хүүхэд, залуучууд ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заалыг барьж, ашиглалтад оруулав.



“ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ” ХӨТӨЛБӨР

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 25 ДУГААР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Нийгэм дэх сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх замаар гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлж, аж төрөх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх;

Зорилтын тоо: **3**
Арга хэмжээний тоо: **21**

Биелэлтийн хувь: **90**



Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн Амын Сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн “Гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг шинээр байгуулж, “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр” байрлан үйл ажиллагаа явуулж эхэллээ.



Дүүргийн 11 дүгээр хороонд Гэр бүл, хүүхэд, ахмадын соёл, амралтын цогцолборыг барьж, ашиглалтад оруулав.




Дүүргийн 16 дугаар хороонд ахмадын амралт, сувиллын газрыг барьж байгуулж байна.



Аян - **8**
Сургалт хэлэлцүүлэг - **189**
Өдөрлөг - **14**
Болзолт уралдаан - **43**
Цахим аян - **2**

“Хүүхдийн тусламжийн утас 108”-д ирсэн
дуудлага



МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

- Телевизийн нэвтрүүлэг - **4**
- Подкаст - **2**
- Чадавхжуулах арга хэмжээ **165**
Нийт **970675** иргэн



СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

- Ганцаарчилсан - **249**
- Хосын зөвлөгөө - **17**
- Гэр бүлийн зөвлөгөө - **282**
Нийт **548** иргэн





**“ХАМТДАА ХӨГЖЬЕ”
ХӨТӨЛБӨР**

**ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 27 ДУГААР
ТОГТООЛ**

ЗОРИЛГО: Иргэдийн оролцоотой орон нутгийн сайн засаглалыг бэхжүүлэх, хөдөлмөрлөх хүсэл сонирхолтой, ажилтай орлоготой иргэдтэй, эрүүл аюулгүй, нээлттэй, хүртээмжтэй ажлын байр, ажиллах таатай орчин нөхцөл бүрдсэн, иргэн бүрийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаатай дүүрэг болох;

Зорилтын тоо: **4**

Биелэлтийн хувь: **89,2**

Арга хэмжээний тоо: **14**



АЖЛЫН БАЙРААР ХАНГАСАН БАЙДАЛ

Он	Бүртгэлтэй ажил хайгч иргэн	Ажилд зуучлагдсан иргэд
2017 он	1569	1222
2018 он	1450	1008
2019 он	1430	1020
2020 он	1150	1000
Нийт	5599	4250



№	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР	2017 он	2018 он	2019 он	2020 оны /эхний хагас жил/	Нийт
		Хамрагдсан иргэдийн тоо				
1	Нийтийг хамарсан ажил	180	301	687	235	1403
2	Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих хөтөлбөр	-	23	82	-	105
3	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ /төсөл/	25	19	22	13	79
4	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ /сургалт/	13	18	12	9	52
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	12	15	18	-	45
6	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	288	131	128	-	547
Нийт		729	658	1055	339	2781



“ЧИНГЭЛТЭЙД ҮЙЛДВЭРЛЭВ” ХӨТӨЛБӨР

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 23 ДУГААР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Жижиг дунд болон өрхийн үйлдвэр эрхлэгч иргэдийг дэмжин үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, шинэ технологи бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү анхаарч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгох, эдийн засагт жижиг дунд үйлдвэрлэлийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх;

Зорилтын тоо: **4**

Биелэлтийн хувь: **84,2**

Арга хэмжээний тоо: **20**



Дүүргийн 7 дугаар хороонд Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулав.



Дүүргийн 16 дугаар хороонд Жижиг, дунд үйлдвэрлэл, инновацын хөгжлийг дэмжих төвийг байгуулав.



Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хүрээнд 16-28 мкв хэмжээтэй зөөврийн ажлын байрыг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2020 оны байдлаар 123 зөөврийн ажлын байрыг бий болгож, 249 иргэдийг ажлын байраар хангав.



Дүүргийн 20 гаруй өрхийн үйлдвэрлэгчид "Баялаг бүтээмж" хоршоог үүсгэн байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.



Дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв"-ийг нээж, үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн борлуулах "Чингэлтэйд үйлдвэрлэв-3" төвийг нээв.



ГАДААД ҮЗЭСГЭЛЭН, ХУДАЛДАА (2017-2019 он)



БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдсан 4 удаагийн үзэсгэлэн худалдаанд дүүргийн 20 өрхийн үйлдвэрлэгчдийг оролцуулав.



БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод зохион байгуулагдсан 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд дүүргийн 36 өрхийн үйлдвэрлэгчдийг оролцуулав.



БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алтан-Эмээл хотод зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд дүүргийн 8 өрхийн үйлдвэрлэгчдийг оролцуулав.



БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод зохион байгуулагдсан 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд дүүргийн 19 өрхийн үйлдвэрлэгчдийг оролцуулав.



Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 750 иргэн, үйлдвэрлэгчдийг дотоодын 39, гадаадын 4 нийт 43 (давхардсан тоогоор) удаагийн үзэсгэлэн худалдаанд хамруулж, үйлдвэрлэгчдийн 419.1 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг амжилттай борлуулав.



Дүүргийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулах "Чингэлтэйд үйлдвэрлэв" төвийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотод байгуулав.



**ГАМШГААС ХАМГААЛАХ
САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАМШИГ ОСОЛ, ГАЛ ТҮЙМРЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨР**

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 30 ДУГААР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Иргэдийг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдал эрсдлийг бууруулах;

Зорилтын тоо: **4**
Арга хэмжээний тоо: **20**

Биелэлтийн хувь: **84,2**



Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдал, эрсдлийг бууруулах зорилго бүхий Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулагдав.



Дүүргийн 1-19 дүгээр хороо бүрт "Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг", хэсэг бүрт "Гамшгаас хамгаалах сайн дурын баг"-ууд байгуулагдав.



Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, бүлэг, багийн нөөцөд тулгуурлан Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх Улсын хэмжээний дадлага, сургуулийг Чингэлтэй дүүрэгт амжилттай зохион байгуулав.




Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгийг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх хөдөлмөр хамгааллын малгай, хорт хий, утаанаас хамгаалах баг, галын бүлгийн хантааз, гал унтраах байлдааны хувцас, хэрэгслээр хангав.



Дүүргийн 12 дугаар хороонд иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах албан өрөөг нээн, тохижуулав.



Гамшгаас хамгаалах дадлага сургуулийг дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 7 удаа, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангид 8 удаа, иргэдэд 50 удаа, аж ахуйн нэгж байгууллагад 69 удаа тус тус зохион байгуулж, дүүргийн 10210 иргэдийг хамруулав.



“НОГООН ДҮҮРЭГ” ХӨТӨЛБӨР

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2017 ОНЫ 22 ДУГААР
ТОГТООЛ

ЗОРИЛГО: Байгальд ээлтэй эко санал санаачилгыг нэвтрүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох, түүнийг арчлах, агаар хөрсний бохирдлыг багасгах, нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 2.0-оос дээш хувьд хүргэн нэмэгдүүлэх замаар иргэд, олон нийтэд экологийн боловсролыг төлөвшүүлж, ногоон хөгжлийг дэмжих;

Зорилтын тоо: **7**
Арга хэмжээний тоо: **16**

Биелэлтийн хувь: **92,5**



Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий 54 ширхэг нарны зайн гэрэлтүүлгийг Самбуугийн гудамж, 17 дугаар хорооны Баянхайрханы 4 дүгээр гудамжинд тус тус суурилуулав.



Дүүргийн 3,12,14,16,15 дугаар хороодод 32 нарны зайн гэрэлтүүлгийг суурилуулж, дүүргийн хэмжээн дэх 12859 гэрэлтүүлгийн 98,2 хувь нь бүрэн асалттай байна.



Дүүргийн хэмжээнд 9 хорооны 17 байршлын 935 өрхийн цахилгааны хүчдэлийг нэмэгдүүлэв.



Дүүргийн хэмжээнд нийт 554 ширхэг камерийг суурилуулж, цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн теле хяналтын системд бүрэн холбож, байнгын хяналтад авав.



Дүүргийн 16 дугаар хороонд "Болзох цэг"-ийн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэв.



Дүүргийн 13, 14, 15 хороодод "Их Галдайн оргил" овооны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэв.



Дүүргийн 18 дугаар хороо Хайлааст - Чингэлтэйн авто замын хажууд Булгийн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэв.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хорооны Булгийн 20 дугаар гудамжинд ногоон байгууламж бүхий хүүхдийн тоглоомын талбайг байгуулав.



Дүүргийн 12 дугаар хороонд агаар, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр иргэдийг мэдээллээр хангах "Мэдээлэл инновацийн нэгдсэн төв"-ийг байгуулав.



Дүүргийн 7 дугаар хорооны Эрх зүйн туслалцааны төвөөс Санбалхүндэвийн эргэмжийн газар хүртэл 0,42 км авто зам тавив.



Дүүргийн 16 дугаар хорооны Чингэлтэй Хайлаастын авто замтай холбогдох 0,65 км авто замыг тавив.



Дүүргийн 15 дугаар хорооны Жаргалантын 34 дүгээр гудамжнаас 18 дугаар хорооны Яргайтын 16 дугаар гудамж хүртэлх 0,68 км авто замыг тавив.



Дүүргийн 18 дугаар хорооны Яргайтын 38 дугаар гудамжнаас Чингэлтэйн замтай нийлэх 0,4 км авто замыг тавив.



Дүүргийн 19 дүгээр хорооны Тахилтын аманд 1,38 км авто замыг тавив.




Дүүргийн 13, 14 дүгээр хороо Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын өргөн чөлөөтэй холбогдох 0,88 км авто замыг тавив.



Дүүргийн 12 дугаар хорооны Нарантуул-2 захаас 13 дугаар хорооны хойд тал хүртэлх 0,7 км авто замыг тавьж байна.



Дүүргийн 13,14 дүгээр хороо Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын авто зам хүртэлх 1,1 км авто замыг тавьж байна.



Дүүргийн хэмжээнд нийт 43 бичил цэцэрлэг, тоглоомын талбайн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.



Дүүргийн 1-6 дугаар хорооны 38 байрны дээвэр, фасад засвар үйлчилгээг жил бүр хийж, дулаалав.



Д/д	Тарилт хийсэн он	Мод	Бут, сөөг	Амьд хашлага	Цэцэг	Зүлэг
			ширхэг		м2	
1	2016	763	5838	25589	410	22334
2	2017	7267	5597	12916	217	10612
3	2018	7796	1697	2800	205	10680
4	2019	27634	24575	5300	490	9040
5	2020	10743	11854	3300	593	25168
Нийт дүн		65353	57199	159955	2153	123820



**ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ГАДААД
ХАРИЛЦААГ ХӨГЖҮҮЛЭХ
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
2018 ОНЫ 29 ДҮГЭЭР
ТОГТООЛ

Зорилтын тоо: **4**
Арга хэмжээний тоо: **16**
Биелэлтийн хувь: **92,5**

ЗОРИЛГО: Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны зарчим, чиглэлийг тодорхойлох, дэлхийн Улс орнуудтай найрсаг харилцаа тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, тэдний тэргүүлэх менежмент, шинэ техник, технологи, сайн туршлагыг дүүрэг, орон нутагтаа нэвтрүүлэх, харилцаа, хамтын ажиллагаанд түшиглэн дүүргийн эдийн засаг, нийгмийн болон бусад салбарыг хөгжүүлэх, Олон Улсын байгууллага, хамтын нийгэмлэг, холбоонд эвлэлдэн нэгдэх, байр сууриа бэхжүүлэх, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын гадаад харилцааны нэгдмэл байдлыг хангах, гадаад бодлого, үйл ажиллагаагаа Улс, Нийслэлээс баримталж буй гадаад бодлоготой уялдуулан зохицуулах;



Бүгд Найрамдах Турк Улсын Анкара хотын Синжан дүүрэгтэй хот тохижилт, гэр хорооллын дахин төлөвлөлт, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, нийгэм, соёлын чиглэлээр хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулав.



Бүгд Найрамдах Солонгос Улсын “Жам Ун Монголиа” ХХК-тай Чингэлтэй дүүрэгт харьяалагдах амьжиргааны түвшин бага, ажилгүй, тогтмол орлогогүй иргэдэд үнэ төлбөргүй шүдний оношилгоо, эмчилгээ хийх, бусад хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулав.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ордос хотын Отог Өмнөд хошууны дээд зэрэглэлийн үндэстний ажил мэргэжлийн сургуультай богино хугацааны мэргэжил олгох хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулав.



Санамж бичгийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 20 багшийг мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамруулав.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хотын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хороотой Хот тохижилт, ногоон байгууламж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр мэргэжилтэн солилцох, жижиг дунд бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны “Санамж бичиг” байгуулав.



Санамж бичгийн хүрээнд Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээний компанийн 10 ажилтныг ногоон байгууламжийн чиглэлээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод богино хугацааны сургалтад хамруулав.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотын Ардын Төлөөлөгчдийн Их Хуралтай соёл урлаг, боловсрол, эрүүл мэнд, худалдаа үйлдвэрлэл, хот тохижилт, аялал жуулчлал зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбаруудад хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулав.



Санамж бичгийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотод “Чингэлтэйд үйлдвэрлэл” төвийг нээв.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж-16

www.chingelteicouncil.mn

www.chingeltei.ub.khural.mn

Утас: 11-313193

Факс: 11-310194

Э-шуудан: ith_office@chingelteicouncil.mn

